

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ОРОН НУТГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ДҮГНЭЛТ ӨГӨХ”

АУДИТЫН КОД: ГСА-2024/03-06-НА-НА

Говьсүмбэр аймаг

2024 он

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын
газрын дарга, тэргүүлэх аудитор:
Б.Сарантуяа, Утас: 70543179
Цахим хаяг: Sarantuyab@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Наранбаяр,
Утас: 70543179
Цахим хаяг: Naranbayarg@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Дарханбат, Утас: 70543179
Цахим хаяг: darkhanbatb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Анхтуяа, Утас: 70543179
Цахим хаяг: Ankhtuyab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу.
Цахим хуудас: www.audit.mn

ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
ААНОАТ	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
АИТХ	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
АМАТ	Ашигт малтмалын ашигласны төлбөр
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
БХНСАХ	Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээ
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗДҮАХ	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НТБТ	Насан туршийн боловсролын төв
СДОА	Сум дундын ойн анги
ОАТ	Орлогын албан татвар
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ТАХ	Төсөл арга хэмжээ
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
УИХ	Улсын их хурал
УССТ	Усан спорт сургалтын төв
ҮАХ	Үйл ажиллагааны хөтөлбөр
ХБТХОХ	Хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтэс
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЦСҮТ	Цөм сүргийн үржлийн төв
ЦХБТАОАТ	Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын татвар
ЭЗНХҮЧ	Эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:	Аудитыг УИХ-ын төсвийн байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоол, МҮЕА-ын 2023 оны А/162 дугаар тушаал, Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө болон Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэлээ.
Аудитын зорилт:	Аймгийн Засаг даргаас ИТХ-д өргөн мэдүүлсэн 2025 оны төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргаж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдсэн. Аудитын зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтуудын дагуу аудитыг гүйцэтгэсэн.Үүнд: ➤ Төсвийн төсөлд төсвийн орлогыг боломжит хэмжээнд нэмэгдүүлж төлөвлөсөн үү? ➤ Төсвийн төсөлд төсвийн зарлагыг боломжит хэмжээнд бууруулж, санхүүжилтийг үр нөлөөтэй ТАХ-д зарцуулахаар төлөвлөсөн үү?
Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт:	Дараах хууль эрх зүйн актын холбогдох заалтуудыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав. ✓ Төрийн аудитын тухай ✓ Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль ✓ Төсвийн тухай хууль ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль ✓ Татварын хуулиуд ✓ Засгийн газрын 2019 оны 312, 2021 оны 160 дугаар тогтоол ✓ Сангийн сайдын 2019 оны А/282, 2021 оны А/86 дугаар тушаал ✓ Холбогдох бусад хууль тогтоомж, хөтөлбөр, гэрээ, эрх зүйн актууд ✓ Аймаг, сумын ИТХ-ын тогтоол, Засаг даргын захирамж, холбогдох шаардлагатай хууль, дүрэм, журам
Аудитын хамарсан хүрээ:	Аймгийн Засаг даргаас Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барьсан орон нутгийн 2025 оны төсвийн төсөл, түүний орлого, зарлагын тооцоо судалгаа, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөлтийн баримт материал, төсвийн шууд захирагчид болон төсвийн төлөвлөлтөд оролцсон бусад байгууллагыг хамрууллаа.
Аудитын арга зүй:	Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 3000-3100, 4000, Гүйцэтгэлийн аудитын үндсэн ойлголтын удирдамж 3910, 3920, Монгол Улсын Төрийн аудитын стандарт, MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт” “Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “ТАБ-аас аудит хийх журам”, түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/81 дүгээр тушаал, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/67 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн төсөлд дүгнэлт гаргах аргачлал”-ыг ашиглан гүйцэтгэсэн. Дээрх стандарт арга зүйн дагуу аудитын үе шатны

**Аудит хийх багийн
бүрэлдэхүүн,
хугацаа:**

ажлыг гүйцэтгэж, аудитын дүн, дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг цуглуулж, ажлын баримт материалд хавсаргасан болно.

Аудитыг дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа хянан удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Дарханбат, Б.Анхтуяа, аудитор С.Батцэцэг, Г.Ариунцэцэг нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Аудитын талбарын ажлыг 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдрөөс эхлүүлж, тайланг Тэргүүлэх аудиторовн тушаалаар баталгаажуулан аймгийн ИТХ болон Засаг даргад 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдөр хүргүүллээ.

Хүндрэл бэрхшээл:

Аудитыг гүйцэтгэхэд шаардлагатай нотлох баримтуудыг төсвийн төслийн хамт ирүүлээгүй, дутуу ирүүлсэн нь хүндрэл учруулж байсан.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газраас “Төрийн аудитын тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 “..., түүнчлэн аймаг, нийслэлийн Засаг даргаас тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн жилийн төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргаж, ... аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэх” гэж заасан бүрэн эрхийн дагуу аймгийн Засаг даргаас иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн орон нутгийн 2025 оны төсвийн төсөлд санал, дүгнэлт гаргалаа.

Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль хэлэлцэн баталсан бөгөөд Монгол Улсын Ерөнхийлөгч 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуульд бүхэлд нь хориг тавьжээ.

Аймгийн Засаг даргаас орон нутгийн 2025 оны төсвийн төслийг Төрийн аудитын байгууллагад 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр А/1143 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуулиар Говьсүмбэр аймгийн орон нутгийн төсвийн нийт орлогын эх үүсвэрийг 36,583.8 сая төгрөгөөр баталсан байна. Үүнд:

- ❖ Төсвийн суурь орлогыг 16,484.1 сая
- ❖ Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 8,374.3 сая
- ❖ Улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг 11,725.4 сая төгрөг байна.

Мөн зарлагыг 36,583.8 сая төгрөгөөр баталсан бөгөөд үүний 77 хувийг төсвийн суурь зарлага эзэлж байна.

- ❖ Төсвийн суурь зарлагыг 28,209.5 сая
- ❖ Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 8,374.3 сая

Дүрслэлийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг, Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгийн харьцуулалт	7
Дүрслэл 2	Орлогын талаар баримтлах чиглэлүүд	7
Дүрслэл 3	Татварын болон татварын бус орлогын харьцаа	8
Дүрслэл 4	Нэмэгдүүлсэн болон бууруулсан орлогыг нэр, төрлөөр нь харуулсан	8

Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Аймгийн 2025 оны төсвийн төсөлд тусгасан орлогыг Сангийн яамны баталсан доод хязгаартай харьцуулсан байдал	8
Хүснэгт 2	2024 оны орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл (10 дугаар сарын 31-ний байдлаар)	9
Хүснэгт 3	Аймгийн 2025 оны төсвийн зарлага	11
Хүснэгт 4	Аймгийн Засаг даргаас 2025 оны орон нутгийн төсвийн нийт зарлагад оруулсан өөрчлөлт	11
Хүснэгт 5	Хөрөнгө оруулалтын төлөвлөлт	13
Хүснэгт 6	“Аймгийн 2025 оны хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ” /сумын ОНХС-д хуваарилагдсан дүн ороогүй/	13
Хүснэгт 7	“Төлөвлөсөн хугацаандаа хийгдээгүй 3 хөрөнгө оруулалт, арга хэмжээ”	14
Хүснэгт 8	Гэрээ байгуулснаас хойш 3-4 жилийн хугацаанд бүрэн хэрэгжиж дуусаагүй хөрөнгө оруулалт, арга хэмжээний жагсаалт	15
Хүснэгт 9	Төлөвлөлтийн шаардлага хангаагүй ажлын жагсаалт	15
Хүснэгт 10	Авто замын тухай хууль, авто замын сангийн журамд нийцээгүй ажлын жагсаалт	18

БҮЛЭГ 1

Төсвийн төсөлд орлогыг төлөвлөхдөө Төсвийн тухай хуулиар баталсан орлогын доод хэмжээний хязгаарыг бууруулан төлөвлөсөн байна.

1.1 Татварын орлогыг өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн төлөвлөсөн байна.


Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуулиар Говьсүмбэр аймгийн орон нутгийн төсвийн нийт орлогын эх үүсвэрийг 36,583.8 сая төгрөгөөр баталсан байна. Үүнд:

- ❖ Төсвийн суурь орлогыг 16,484.1 сая
- ❖ Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 8,374.3 сая
- ❖ Улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг 11,725.4 сая төгрөг байна.

Мөн зарлагыг 36,583.8 сая төгрөгөөр баталсан бөгөөд үүний 77 хувийг төсвийн суурь зарлага эзэлж байна.

- ❖ Төсвийн суурь зарлагыг 28,209.5 сая
- ❖ Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 8,374.3 сая

Орлогын эх үүсвэрийг 2024 онтой харьцуулж харуулбал:

Дүрслэл №1

Дүрслэлээс харахад: Өмнөх онтой харьцуулахад улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг 73, орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 25, суурь орлого 45 хувиар тус тус өссөн байна.

Эх сурвалж: Аймгийн Засаг даргаас өргөн мэдүүлсэн 2025 төсвийн төсөл

2025 оны төсвийн төсөлд орлогын талаар дараах 4 чиглэлийг баримталж ажиллахаар тусгасан байна. Тухайлбал:

Дүрслэл №2. Орлогын талаар баримтлах чиглэлүүд

Тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийг татварын удирдлагын нэгдсэн системд бүртгүүлэх ажлыг эрчимжүүлэх, мөн харьяа татварын албатай хамтран татвар төлөгчийн цахим төлбөрийн баримтын бүртгэлийн хяналт тавих ажлыг зохион байгуулах

Усны нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх чиглэлээр сум, дүүргийн Засаг дарга, Усны газар, сав газрын захиргаа, төвлөрсөн ус хангамжийн байгууллага, татварын алба ус ашиглагчийн үйлдвэр, үйлчилгээнд ашигласан усны хэмжээг бодитоор тодорхойлон, төлбөрийн орлогыг орон нутгийн төсөвт бүрэн төвлөрүүлэхэд хамтран ажиллах

Татварын ерөнхий хуулийн дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээ гүйцэтгэгч татварын албанд татварын өртэй тохиолдолд улсын төсвийн санхүүжилтээс татварын өрд суутган тооцох ажлыг үргэлжлүүлэх

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6.10-д “аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 40 хувь” гэж заасан Сангийн яам хянасан орлогыг нэмэгдүүлэхгүй байх

Эх сурвалж: Аймгийн Засаг даргаас өргөн мэдүүлсэн 2025 төсвийн төсөл

Аймгийн 2025 оны төсвийн төсөлд тусгасан орлогыг Сангийн яамны баталсан доод хязгаартай харьцуулахад дараах байдалтай байна.

Хүснэгт №1


(сая.төг)

№	Орлогын нэр төрөл	Сангийн яам хянасан	2025 оны төсөв	Зөрүү
1	ТӨСВИЙН НИЙТ ОРЛОГО	16,484.1	16,915.1	431.0
2	ТАТВАРЫН ОРЛОГО	15,008.1	15,298.1	290.0
3	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,476.0	1,617.0	141.0

Хүснэгтээс харахад 2025 оны төсөвт татварын орлогыг 290.0 сая, татварын бус орлогыг 141.0 сая, нийт 431.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Дүрслэл №3. Татварын болон татварын бус орлогын харьцаа

(сая.төг)



Эх сурвалж: Аймгийн Засаг даргын 2020-2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дүрслэлээс харахад: Нийт орлогын дүнд эзлэх татварын бус орлогын дүн 2021 оноос эхлэн 2.1-6%-иар буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь Сангийн яам орлогын төлөвлөлтөөр татварын ачааллыг жил ирэх бүр нэмэгдүүлж, татварын хувь хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр татварын хамрагдалт, татварын бааз суурийг өргөжүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлсэнтэй холбоотой байна.

1.2 Төсвийн тухай хуулиар баталсан орлогын доод хэмжээний хязгаарыг зөрчиж, 3 нэр төрлийн 494.0 сая төгрөгийн татварын орлогыг төсвийн төсөлд бууруулсан байна.

Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуулиар Говьсүмбэр аймгийн 2025 оны төсвийн нийт орлогын эх үүсвэрийг 36,583.8 сая төгрөгөөр баталсан бөгөөд аймгийн Засаг даргаас 2025 оны төсвийн төсөлд орлогын эх үүсвэрийг 4,901.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 41,485.1 сая төгрөгөөр батлуулахаар аймгийн ИТХ-д өргөн барьсан байна. Орлогын эх үүсвэрийг дараах байдлаар нэмэгдүүлэн төлөвлөжээ. Үүнд:

1. Суурь орлого: Нийт 431.0 сая

- ❖ Татварын орлого- 4 нэр төрлийн орлогыг 594.0 сая төгрөгөөр бууруулж, 2 нэр төрлийн орлогыг 884.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн.
- ❖ Татварын бус орлого-141.0 сая

2. Бусад орлого: Нийт 4,470.4 сая

- ❖ Аймаг, сумдын 2024 оны давсан орлого, хэмнэгдсэн зардал – 3,313.4 сая
- ❖ ОНХС, ОНХО-ын он дамжин хийгдэх ажлуудын эхний үлдэгдлээс – 1,157.0 сая

Дүрслэл №4. Нэмэгдүүлсэн болон бууруулсан орлогыг нэр, төрлөөр нь харуулбал

Татварын орлого
- Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого-594.0 сая, дуудлага худалдааны орлого-290.0 сая, нийт 884.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн - Үйл ажиллагааны орлого 80.0 сая, хөрөнгийн орлого 260.0 сая, ус, рашааны нөөц ашигласны төлбөр 154.0 сая, нийт 494.0 сая төгрөгөөр тус тус бууруулсан - Малын тоо, толгойд ногдох албан татварын орлогыг 2025 онд төлөвлөөгүй.

Татварын бус орлого
- Төсөвт байгууллагын өөрийн орлого-41.0 сая / ЦСҮТ-ийн орлогыг 20.0 сая төгрөгөөр бууруулж, УССТ 20.0 сая, СДОА 20.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн/ - Түрээсийн орлогыг 100.0 сая төгрөгөөр нэмэгдүүсэн

Малын тоо, толгойд ногдох албан татварын орлогыг төлөвлөгөөгүй нь цаг агаарын хүндрэлтэй байдлын улмаас малын тоо толгой хорогдож, малчдын амьжиргаа буурсантай холбоотой төлөвлөөгүй байна.

Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого, дуудлага худалдааны орлогыг өмнөх оны гүйцэтгэл, тухайн байгууллагын ирүүлсэн саналд үндэслэн тус тус төлөвлөжээ.

Дуудлага худалдааны орлогыг өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн нэмэгдүүлсэн нь орлогын төлөвлөгөө биелэхгүй байх эрсдэлтэй байна.

Хүснэгт №2 2024 оны орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл (10 дугаар сарын 31-ний байдлаар)

сая.төг

Орлогын нэр төрөл	2024 оны орлогын батлагдсан дүн	2024 оны 10 дугаар сарын орлогын төлөвлөгөө	2024 оны 10 дугаар сарын гүйцэтгэл	Биелэлтийн хувь
Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	8,249.4	6,607.9	7,997.1	121.0
Үйл ажиллагааны орлого	130.0	121.7	163.7	134.5
Хөрөнгийн орлого	305.0	253.5	317.6	125.3
Хөрөнгө борлуулсны орлого	185.0	150.4	268.4	178.5
Шууд бус орлого	733.4	559.1	706.7	126.4
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(408.0)	(408.0)	(398.0)	97.5
Малын тоо, толгойд ногдох албан татвар	163.1	81.5	59.1	72.5
Аж ахуй нэгжийн орлогын албан татвар	600.0	500.0	600.0	120.0
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	820.0	615.0	491.6	79.9
Бууны албан татвар	5.0	5.0	3.4	68.0
Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	150.0	130.0	153.0	117.7
Улсын тэмдэгтийн хураамж	101.8	84.4	104.3	123.6
Газрын төлбөр	520.0	390.0	260.9	66.9
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	65.0	65.0	58.1	89.4
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	190.0	158.3	172.4	108.9
Дуудлага худалдааны орлого	300.0	275.0	293.7	106.8
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	40.0	40.0	177.7	444.3
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	450.0	320.0	291.4	91.1
Түрээсийн орлого	54.0	45.0	27.1	60.2
Хүү, торгуулийн орлого	1,311.7	1,217.5	1,923.3	158.0

Хүснэгтээс харахад: Малын тоо, толгойд ногдох албан татвар, бууны албан татвар, газрын төлбөр, түрээсийн орлогын гүйцэтгэл 60.2-72.5%-тай байна. 2021-2023 онд бууны албан татвар 4.1-10.6%, түрээсийн төлбөр 14.6-30%, малд ногдуулах албан татвар 2022-2023 онд 39.1-51.5%-аар тус тус орлогын төлөвлөгөө тасарсан байна. Энэ нь жилийн эцсээр орлогын төлөвлөгөө татварын нэр, төрлөөр биелэхгүй байх эрсдэлтэй байна.

Аймгийн Татварын газрын ирүүлсэн тооцооллоор 2024 оны жилийн эцсээр үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар, бууны албан татвар, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр, газрын төлбөр, ус рашааны нөөц ашигласны төлбөр, малын тоо толгойд ногдуулах албан татварын орлогын төлөвлөгөө 6.2-18.4%-иар тус тус тасрах магадлалтай байна.

ОРЛОГО НЭМЭГДҮҮЛЭХ САНАЛ:

Аймгийн 2025 оны төсвийн төсөлд орлогыг нийт 740.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэх саналтай байна.

Татварын орлогыг нэмэгдүүлэх санал:

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8-д зааснаар Төсвийн тусгай шаардлага, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн төсвийн ерөнхийлөн захирагчийн тухайн жилийн төсөв боловсруулахад баримтлах **орлогын доод хэмжээ**, зарлагын дээд хэмжээг "жилийн төсвийн хязгаар" гэнэ.

Аймгийн Засаг даргаас өргөн мэдүүлсэн 2025 оны төсвийн төсөлд Сангийн яамнаас хянаж, УИХ-аар батлагдсан орлогын төлөвлөгөөг 494.0 сая төгрөгөөр бууруулсан нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8, 4.1.9¹ 41 дүгээр зүйлийн 41.2.1²-т заасныг зөрчсөн тул **татварын орлогыг 494.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх саналыг хүргүүлж байна.**

Татварын бүс орлогыг нэмэгдүүлэх санал:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2³, 28 дугаар зүйлийн 28.5⁴, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 49 дүгээр тогтоолын дагуу түрээсийн төлбөрийн доод жишиг үнийг баталсан бөгөөд аймгийн хэмжээнд орон сууцны түрээсийн хувьд зах зээлийн үнээс 11 дахин бага үнээр түрээсэлж байгаа бөгөөд метр квадратыг аймгийн төвд 5000, сумын төвд 2500 төгрөг, ААНБ-ын түрээсийн хувьд метр квадратыг аймгийн төвд 7000, сумын төвд 3000 төгрөг болгон шинэчлэн тогтооход нийт **190.3 сая** төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой талаар аймгийн ОНӨГ судалгаа хийсэн байна. Иймд нийт **44.3 сая төгрөгийн орлого нэмэгдүүлэх саналыг хүргүүлж байна. Үүнд:**

- Аймгийн ОНӨГ-ын тооцоололд үндэслэн түрээсийн орлогыг **34.3 сая** төгрөгөөр нэмэгдүүлэх
- УССТ-ийн өөрийн орлогыг өмнөх оны гүйцэтгэл, 2024 оны ХБГ-д үндэслэн **10.0 сая** төгрөгөөр нэмэгдүүлэх

Хэмнэгдсэн зардлаас орлого нэмэгдүүлэх санал:

Орон нутгийн 2025 оны төсвийн төсөлд аймаг, сумдын 2024 оны давсан орлого, хэмнэгдсэн зардлыг 3,313.4 сая төгрөгөөр төлөвлөсөн.

Үүнээс 17 төсвийн байгууллагын 1,068.6 сая төгрөгийг зардлын хэмнэлтэд тооцож дараа оны эх үүсвэрт төлөвлөсөн байна.

17 төсвийн байгууллагын 2024 оны 11 сарын байдлаарх төсвийн гүйцэтгэлд хийсэн дүн шинжилгээгээр урьдчилсан байдлаар хамгийн багадаа 1,270.2 сая төгрөгийн хэмнэлт үүсэх боломжтой тооцоолол хийсэн тул орон нутгийн 2025 оны төсвийн төсөлд 2024 оны хэмнэгдсэн зардлаас **202.2 сая төгрөгийг нэмэгдүүлэх саналыг хүргүүлж байна.** /Дэлгэрэнгүйг хавсралт №1-ээс үзнэ үү/

¹ 4.1.9."төсвийн орлого" гэж хууль тогтоомжийн дагуу улсын болон орон нутгийн төсөв бүрдүүлэх орлого, төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг;

² 41.2.1.хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх;

³ 11.2/ төрийн өмчийн эд хөрөнгийн анхан шатны бүртгэл, тооллого, тайлан тэнцэл гаргах ажлыг зохион байгуулж удирдах, төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтад хяналт тавьж, түүний үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авах

⁴ 28.2.5. Төрийн өмчийн түрээсийн төлбөрийг улсын төсөвт оруулна. Уг төлбөр тухайн эд хөрөнгийг худалдан авах үнийн төлбөрт үл хамаарна.

БҮЛЭГ 2

Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын зарим ажлууд нь төлөвлөлтийн шаардлагад нийцээгүй, төсвийн зарлагыг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөөгүй байна

2.1 Төсвийн урсгал зардлын төлөвлөлтийг Засгийн газрын 2019 оны 445 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн төсвийн суурь зарлагыг тооцох аргачлал”-ын дагуу тооцож төлөвлөөгүй байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5-т “Хөгжлийн асуудал хариуцсан аймаг, нийслэлийн байгууллагууд Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд суурилсан Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг 9 дүгээр сарын 01-ний дотор боловсруулна”, 18.6-т “Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг жил бүрийн 10 дугаар сарын 01-ний дотор батална” гэж заасан.

Мөн Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7-д зааснаар “Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” гэж Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Хөгжлийн зорилтот хөтөлбөрт суурилсан орон нутгийн онцлогийг тусгасан дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичгийг хэлнэ.


Аймгийн Засаг даргаас 2025 оны аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөний төслийг хуулийн хугацаанд багтааж, аймгийн ИТХ-д өргөн барьж батлуулаагүй байна.

Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Говьсүмбэр аймгийн 2025 оны жилийн хөгжлийн төлөвлөгөө аудитын хугацаанд эцэслэн боловсруулагдаж батлагдаагүй тул аймгийн 2025 оны төсвийн төсөл нь бодлогын баримт бичигт нийцсэн байдлыг дүгнэх боломжгүй байна.

Аймгийн 2025 оны төсвийн нийт зарлага 36,583.8 сая төгрөгөөр хянагдан батлагдаж ирсэн байна. Үүнд:

- ❖ Төсвийн суурь зарлагыг 28,209.5 сая
- ❖ Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 8,374.3 сая

УИХ-аас баталсан төсвийн суурь зардал, ОНХС-гийн шилжүүлгийг өмнөх онтой харьцуулж үзвэл:



УИХ-аас батлагдаж ирсэн 36,583.8 сая төгрөгийн төсвийн зарлагыг ТЕЗ-аас 4,901.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж, нийт зарлагыг 41,485.1 сая төгрөгөөр батлуулахаар төсвийн төслийг ирүүлсэн байна.

Төсвийн нийт зарлагын бүтцийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №3 “Аймгийн 2025 оны төсвийн зарлага” (сая.төг)

Төсвийн зарлагын нэр	УИХ-аас хянасан төсөв	2024 оны төсвийн төсөл	Зөрүү
Орон нутгийн суурь зардал	28,209.5	26,684.7	-1,524.8
ОНХС-гийн зардал	8,374.3	9,008.5	634.2
ОНХО-ын зардал		5,791.9	5,791.9
Нийт дүн	36,583.8	41,485.1	4,901.3

(Эх сурвалж: Аймгийн Засаг даргын өргөн барьсан төсөв, Сангийн яамнаас ирүүлсэн суурь зардлын төлөвлөгөө)

Аймгийн Засаг даргаас 2025 оны орон нутгийн төсвийн төслийн нийт зарлагад дараах байдлаар өөрчлөлт оруулан төлөвлөж, санал ирүүлсэн байна. Үүнд:

Хүснэгт №4 (сая.төг)

№	Байгууллагын нэр	Нэмсэн	Хассан	Зөрүү
1	Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	302.9		302.9
2	Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал		(56.6)	(56.6)
3	Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар	854.9		854.9
4	Төрийн болон орон нутгийн өмчийн барилгын үйлчилгээ ашиглалт /ОН-ОН/		(532.0)	(532.0)
5	Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар	693.5		693.5
6	Захирагчийн ажлын алба		(270.3)	(270.3)
7	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба		(20.8)	(20.8)
8	Цөм сүргийн хөгжлийн төв		(139.1)	(139.1)
9	Орон нутгийн өмчийн газар		(102.6)	(102.6)
10	Худалдан авах ажиллагааны газар		(12.4)	(12.4)
11	Нийтийн тээврийн алдагдалд олгох татаас		(10.0)	(10.0)
12	Ойн анги	94.7		94.7
13	Биеийн тамир /Усан спорт/	173.3		173.3
14	Соёлын байгууллага, коллеж, нэгдсэн эмнэлгийн байр ашиглалтын зардал, урсгал засвар		(3,276.)	(3,276.)
15	Хот байгуулалт, тохижилт	332.7		332.7
16	Аймгийн байгаль орчныг хамгаалах газар	115.3		115.3
17	Насан туршийн боловсролын төв	10.0		10.0
18	Улсын төсвийн байгууллагын ТЗ-ны албан хаагч нарт ОНН-20 хувь	1,200.0		1,200.0
Дүн		3,777.3	(4,419.8)	(642.6)
1	АЗДТГ-Засаг даргын хэрэгжүүлэх үйл ажиллагаа	1,150.0		1,150.0
2	Орон нутгийн хөрөнгө оруулалт	3,697.3		3,697.3
3	Авто замын сан	168.2		168.2
4	Аймгийн халамжийн сан	0.1		0.1
5	БОАЖГ-Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх		(105.9)	(105.9)
6	Орон нутгийн хөгжлийн сан	634.2		634.2
Дүн		5,649.8	(105.9)	5,543.9
Нийт		9,427.1	(4,525.8)	4,901.3

(Эх сурвалж: Аймгийн Засаг даргаас өргөн мэдүүлсэн 2025 оны төсвийн төсөл, түүнд хийсэн аудитын тулган баталгаажуулалтын ажлын баримт)

Хүснэгтээс харахад: Төсвийн байгууллагуудын суурь зардалд 3,777.3 сая төгрөгийг нэмж 4,419.9 сая төгрөгийг хасаж, төсвийн зохицуулалтыг хийсэн байна. Нэмсэн зардлын 2,470.9 сая төгрөг буюу 65 хувийг цалингийн нэмэгдэл, 1,306.4 сая буюу 35 хувийг бараа үйлчилгээний зардал эзэлж байна. Мөн Засаг даргын хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардал болон хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний зардлыг 5,649.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж, БХНСАХЗ-аас 105.9 сая төгрөгийг 3 суманд хуваарилсан байна.

ТӨСВИЙН ЗАРЛАГЫГ БУУРУУЛАХ САНАЛ:

Аймгийн 2025 оны төсвийн төсөлд хууль дүрэм, журамд нийцээгүй нийт 100.5 сая төгрөгийн зарлагыг бууруулах, 80.0 сая төгрөгийг хууль тогтоомжид нийцүүлэх дараах саналыг гаргаж байна.

Төсвийн зарлагыг бууруулах санал:**1. Аймгийн ИТХурал-7.5 сая**

- Төсвийн тухай хуулийн 6 дугаар 6.4.1⁵, 31.1.3⁶, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7 “бодитой байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3⁷, Засгийн газрын 2019 оны 445-р тогтоолоор батлагдсан “Орон нутгийн төсвийн суурь зарлагыг тооцох аргачлал”-ын 3.4.4⁸-т заасны дагуу төлөвлөөгүй 7.5 сая төгрөгийн тээвэр шатахууны зардлыг бууруулах

2. Аймгийн ЗДТГазар-61.7 сая

- Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1⁹, 31 дүгээр зүйлийн 31.1.3¹⁰, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7 “бодитой байх” Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3¹¹, Засгийн газрын 2019 оны 445 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн төсвийн суурь зарлагыг тооцох аргачлал”-ын 3.4.4¹²-т заасны дагуу төлөвлөөгүй **20.5 сая** төгрөгийн тээвэр шатахууны зардлыг бууруулах
- Төсвийн тухай хуулийн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 31 дүгээр зүйлийн 31.1.3, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2¹³, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” журмын дагуу норм зөвлөн эдлэлийн зардлыг нормын хувцас, зөвлөн эдлэл ашигладаггүй байгууллагад **8.5 сая** төгрөгийг төлөвлөсөн тул уг зардлыг бууруулах /СХДАА-0.5, Сүмбэр 1.0, Шивээ, Баянтал ЗДТГ-0.5, АЗДТГ-6.0/
- Засгийн газрын 2024 оны 163-р тогтоолын дагуу бичиг хэрэг, шуудан холбооны зардлыг 50%-иар бууруулж төлөвлөхдөө 3 байгууллагын /АЗДТГ-10.0 сая, СЗДТГ-3.0 сая, СДОА-0.2 сая/ холбогдох зардлыг дутуу тооцож бууруулсан тул **13.2 сая** төгрөгийн зардал бууруулах
- Засаг даргын хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7¹⁴ дахь заалтаар хориглосон тэмдэглэлт өдрүүдэд зориулж **19.5 сая** төгрөгийн төсөв зарцуулах үйл ажиллагаа төлөвлөсөн тул уг зардлыг бууруулах

3. Энх тус дэм ӨЭМТ-31.3 сая

- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.18 “төрийн болон орон нутгийн өмчийн боловсрол, эрүүл мэнд, нийгэм, соёлын байгууллагын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засвар”, 21 дүгээр зүйлийн 21.1-т заасан аймгийн чиг үүрэгт

⁵ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах

⁶ жилийн төсвийн хязгаарт багтаасан байх

⁷ сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх

⁸ тээвэр шатахууны зардлын хэмжээг дараахь томъёогоор тооцно:

⁹ 6.4.1 төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах

¹¹ 15.2.3 сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх

¹² 3.4.4 тээвэр шатахууны зардлын хэмжээг дараахь томъёогоор тооцно:

¹³ 8.2 Энэ хуулийн 8.1-д Үндсэн хуулийн цэцийн гишүүний болон шүүгчийн өмсгөл, эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах, зам тээврийн салбарын ажилтнуудын хуульд заасан тусгай хувцас болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 15.1-д заасан тусгай хувцас хамаарахгүй.

¹⁴ 24.7 Төсвийн хөрөнгө, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрд болон орон нутагт ногдох хөрөнгийг Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдөр, тэдгээртэй адилтгах аливаа өдөрлөг, ойн баярт зориулж зарцуулахыг хориглоно.

хамааралгүй урсгал зардлыг төлөвлөсөн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “үр ашигтай байх”, 4.1.7 “бодитой байх”, 4.1.9 “хариуцлагатай байх”, Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/320 тушаалаар батлагдсан “Өрхийн эрүүл мэндийн төвийн дүрэм”-ийн 1.12-т “Төвийн хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай зориулалтын байр, багаж тоног төхөөрөмж, машинаар хангахад дэмжлэг үзүүлэх талаар Эрүүл мэндийн газрын дарга, Өрхийн эрүүл мэндийн төвийн даргатай байгуулсан гүйцэтгэлийн гэрээнд тусгаж, аймаг, нийслэлийн Засаг дарга баталж хэрэгжүүлнэ”, 6.1-д “Төвийн төсөв нь улсын болон эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв. бусад эх үүсвэрээс бүрдэнэ” гэж заасныг тус тус зөрчиж орон нутгийн төсвөөс тогтмол зардлын санхүүжилтийг олгохоор төлөвлөсөн тул зардлыг 31.3 сая төгрөгөөр бууруулах

Төсвийн хөрөнгийн төлөвлөлтийг сайжруулах санал:

- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.1.3, 4.1.7, 4.1.9, Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.17¹⁵, 4.1.24¹⁶ 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтыг зөрчиж, Гамигаас хамгаалах арга хэмжээний зардлаас хөрөнгө бэлтгэх зорилгоор ачааны авто машин 30.0 сая, дулаан мэдрэгчтэй дрон 50.0 сая төгрөгөөр худалдан авахаар төлөвлөснийг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд баталж, Төсвийн тухай хуульд нийцүүлэх

2.2 Хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн шаардлагад нийцээгүй нийт 6,095.2 сая төгрөгийн 13 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.

Ерөнхий мэдээлэл:

ТЕЗ-аас хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэхдээ 2024 оны хэмнэгдсэн зардал, давсан орлогоос 3,174.5 сая, 2024 оны ОНХО-ын хэмнэлт 141.0 сая, шилжих ажил 349.6 сая, ОНХС-ийн хэмнэлт 157.3 сая төгрөг, шилжих ажил 477.0 сая, Авто замын сангийн шилжих ажил 32.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, нийт 4,331.6 сая төгрөгөөр өөрчлөлт оруулж, батлуулахаар санал оруулжээ.

Хөрөнгө оруулалтын төлөвлөлт

Хүснэгт №5

(сая.төг)

Төсвийн зарлагын нэр	УИХ-аас хянасан төсөв	Аймгийн СТСХ-ээс зохицуулалт хийсэн	2025 оны төсвийн төсөл	Зөрүү
ОНХС-гийн зардал	8,374.2	8,374.2	9,008.5	634.3
ОНХО-ын зардал	0	2,094.6	5,791.9	3,697.3
Нийт дүн	8,374.2	10,468.8	14,800.4	4,331.6

(Аймгийн Засаг даргаас өргөн мэдүүлсэн 2025 оны төсвийн төсөл)

Говьсүмбэр аймгийн 2025 оны төсвийн төсөлд аймгийн ОНХО, ОНХС, Авто замын сан, Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас санхүүжүүлж шинээр хэрэгжүүлэх 10,026.4 сая төгрөгийн 50, он дамжин хэрэгжих 858.6 сая төгрөгийн 10, нийт 10,885.0 сая төгрөгийн 60 хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

“Аймгийн 2025 оны хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ”

/сумын ОНХС-д хуваарилагдсан дүн ороогүй/

Хүснэгт №6

(сая.төг)

№	Хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ	Орон нутгийн хөгжлийн сан	Орон нутгийн хөрөнгө оруулалт	Авто замын сан	БХНСАХ	Нийт
1	Хөрөнгө оруулалт	3,166.3	1,978.0	847.0	60.0	6,051.3
2	Их засвар	-	2,124.0	-	-	2,124.0

¹⁵ 4.1.17 "арга хэмжээ" гэж хөтөлбөрийн бүрэлдэхүүнд багтах, тоо хэмжээ, цаг хугацаа, чанарын шалгуур үзүүлэлтээр тодорхойлогдох ажил, үйлчилгээг;

¹⁶ 4.1.24."төсвийн хөрөнгө оруулалт" гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг;

3	Тоног төхөөрөмж	-	840.3	-	-	840.3
4	Зураг төсөв	10.3	500.0	-	-	510.3
5	Хөтөлбөр, төсөл арга хэмжээ	-	-	295.0	205.4	500.4
6	Шилжих хөрөнгө оруулалт	476.9	349.6	32.2	-	858.6
Дүн		3,653.5	5,791.9	1,174.2	265.4	10,885.0

(Аймгийн Засаг даргаас өргөн мэдүүлсэн 2025 оны төсвийн төсөл)

Хүснэгтээс харахад: Нийт санхүүжүүлэхээр тооцсон төсөвт өртгийн 6,051.3 сая төгрөг буюу **56 хувийг** хөрөнгө оруулалтын ажилд зарцуулахаар төлөвлөжээ. Өмнөх онд нийт төсвийн **41 хувийг** хөрөнгө оруулалтад төлөвлөсөн байна.

Орон нутгийн хөгжлийн сан

Улсын Их Хурлаас орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлгийг 8,374.3 сая төгрөгөөр баталсан бөгөөд үүнээс сумдад 5,355.0 сая төгрөгийг хуваарилж 3,019.3 сая төгрөгөөр аймгийн ОНХС-г баталсан байна.

Аймгийн ОНХС-д төлөвлөсөн хугацаандаа хэрэгжээгүй 2025 онд шилжих 5 ажлын 477.0 сая, 2024 онд хийгдээгүй хэмнэлтээр үлдсэн 3 ажлын 112.7 сая, гэрээний хэмнэлт 44.6 сая, нийт 634.3 сая төгрөгөөр эх үүсвэр нэмэгдэж, 3,653.5 сая төгрөгийг батлуулахаар аймгийн ИТХ-д өргөн барьсан байна.

“Төлөвлөсөн хугацаандаа хийгдээгүй 3 хөрөнгө оруулалт, арга хэмжээ”

Хүснэгт №7

(сая.төг)

№	Төсөл арга хэмжээний нэр	Төсөл, арга хэмжээний ангилал	Төсөвт өртөг
1	Нийтийн эзэмшлийн талбайн засвар үйлчилгээний ажил	Хөрөнгө оруулалт	35.7
2	Жорлонгоо өөрчилье аян	Төсөл, арга хэмжээ	52.0
3	Шивээговь суманд ахуйн үйлчилгээний барилгын холболтын зураг төсөв боловсруулах ажил	Тоног төхөөрөмж	25.0
Нийт дүн			112.7

(Эх сурвалж: АЗДТГ-аас ирүүлсэн судалгаа, хөрөнгө оруулалтын баримт, гүйцэтгэлийн судалгаа)

Төсвийн төсөлд тусгасан хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ нь холбогдох эрх зүйн акттай нийцэж буй эсэхийг шалгахад Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.1.3, 4.1.7, 4.1.9, Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4¹⁷, Барилгын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.5¹⁸, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.3.3¹⁹, Сангийн сайдын 2012 оны 244-р тушаалын хавсралтаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 6 дугаар зүйлийн 6.3.3²⁰ -т заасныг зөрчиж зураг төсөв нь магадлалаар баталгаажуулаагүй 1,800.0 сая төгрөгийн гадна дулааны шугам, цахилгаан хангамжийн ажлыг төлөвлөсөн байна.

¹⁷ 29.4 Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

¹⁸ 25.2.5.энэ хуулийн 10.1.2, 10.1.3-т заасан ангилалд хамаарах улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр барих барилга, байгууламжийн төсөв, нэгдсэн төсөв.

¹⁹ 4.3.3 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, бусад холбогдох зөвшөөрөлтэй байх;

²⁰ 6.3.3. хөрөнгө, оруулалтын төсөл хөтөлбөр арга хэмжээ нь хуульд заасны дагуу техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөв нь батлагдсан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдсэн, бусад зөвшөөрөлтэй байх;

Төсөвт өртгийг баталгаажуулаагүйгээс ажлыг гүйцэтгэх явцад төсөвт өртөг нэмэгдэх, төлөвлөсөн хугацаандаа хэрэгжихгүй байх сөрөг нөлөөтэй асуудлууд өмнөх жилүүдэд үүсэж байсан бөгөөд давтагдах эрсдэлтэй байна.

Төсвийн санхүүжилтийн үр ашгийг сайжруулах санал-1,800.0 сая

Төлөвлөлтийн шаардлага хангаагүй 1,800.0 сая төгрөгийн “Шинээр баригдах орон сууцуудын дэд бүтцийг сайжруулах ажил”-ыг төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор магадлалаар баталгаажсан зураг төсөвт нь үндэслэн батлах саналыг аймгийн ИТХ-д хүргүүлж байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалт

Аймгийн Засаг даргаас 2025 оны төсвийн төслийг ирүүлэхдээ УИХ-аас баталсан төсөвт 2,094.6 сая төгрөгийн зардлын бүлэг хооронд зохицуулалт хийн ОНХО-д шилжүүлэн бусад эх үүсвэрээс 3,697.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 2025 онд 5,442.9 сая төгрөгийн 25, өмнөх оноос шилжсэн 349.6 сая төгрөгийн 4 хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг төлөвлөсөн байна.

Хугацаандаа хэрэгжээгүй 2025 онд шилжсэн 4 ажлын 2 нь өмнөх онуудаас дамжсан байна.

Гэрээ байгуулснаас хойш 3-4 жилийн хугацаанд бүрэн хэрэгжиж дуусаагүй хөрөнгө оруулалт, арга хэмжээний жагсаалт

Хүснэгт №8

(сая.төг)

№	Төсөл, арга хэмжээний нэр	Гэрээ байгуулсан огноо	Гэрээ байгуулснаас хойших хоног	Гэрээний дүн	Олгосон санхүүжилт	Үлдэгдэл
1	1-р багт дахин төлөвлөлт хэрэгжүүлэх байршилд ерөнхий төлөвлөгөөний зураг төсөв боловсруулах	2021-02-21	(1,376)	18.4	9.2	9.2
2	Шинэ суурьшлын бүс үүсгэх зураг төсөв	2022-07-18	(865)	22.5	15.8	6.7
Нийт			(2,241)	40.9	25.0	15.9

(Эх сурвалж: АЗДТГ-аас ирүүлсэн судалгаа, хөрөнгө оруулалтын баримт)

Ажлын даалгаврыг оновчтой боловсруулахгүй байгаагаас шалтгаалж зураг төсвийн ажлууд төлөвлөсөн хугацаандаа хэрэгжихгүй байна. Энэ нь дараа жилийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээ батлагдсан зураг төсөвгүй хууль зөрчиж батлагдах шалтгаан болж байна.

Тухайлбал: 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан 4 зураг төсөв магадлалаар баталгаажиж ирээгүй бөгөөд үүнээс шалтгаалж 2025 онд ОНХО-р хэрэгжих 3 хөрөнгө оруулалтын ажил хуульд заасан шаардлагыг хангаагүй байна.

Төлөвлөлтийн шаардлага хангаагүй ажлын жагсаалт

Хүснэгт №9

(сая.төг)

№	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Зөрчил	Тайлбар
1	Өгөөж захын уулзвараас 2 дугаар сургуулийн уулзвар хүртэлх авто замын ажил	1,000.0	Төсвийн тухай хуулийн 29.4, Барилгын тухай хуулийн 25.2.5, ЗГ-ын 2023 оны 278 дугаар тогтоолын 3.2.2.2-т заасны дагуу сүүлийн 2 жилийн хугацаанд	2024 онд 20.0 сая төгрөгөөр зураг төсөв боловсруулах төсөв нь батлагдсан боловч эцсийн байдлаар хүлээн аваагүй.
2	Авто замын үерийн хамгаалалтын барилга байгууламж	200.0		2024 онд 15.0 сая төгрөгөөр зураг төсөв боловсруулах төсөв нь батлагдсан боловч эцсийн байдлаар хүлээн аваагүй.
3	Халдвартын эмнэлгийн их засварын ажил	550.0		2021 онд ММ Архитектур ХХК-иар 14.8 сая төгрөгөөр хийгдсэн зураг төсөвтэй боловч ашиглаагүй.

4	Усан спорт сургалтын төвийн засварын ажил	400.0	магадлалаар баталгаажсан зураг төсөвтэй шаардлагад нийцээгүй.	2024 онд засварын ажлын зураг төсөвт 20.0 сая төгрөг баталсан боловч эцсийн байдлаар хүлээн аваагүй.
5	Эрүүл мэндийн газрын хуучин барилгыг оффиссын зориулалтаар засварлах ажил	361.3		361.3 сая төгрөгийн төсөвтэй боловч зураггүй. Мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргуулаагүй.
6	Хуучин хүүхдийн эмнэлгийг оффиссын зориулалтаар засварлах ажил	480.0		582.3 сая төгрөгийн төсөвтэй боловч зураггүй. Мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргуулаагүй.
Нийт		2,991.3		

(Эх сурвалж: Аудитын ажлын баримт)

Хүснэгтээс харахад: **Хууль, журамд заасан магадлалаар баталгаажсан зураг төсөвтэй байх, мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулсан байх шаардлагыг хангаагүй Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.1.3, 4.1.7, 4.1.9 дэх заалтыг зөрчсөн 6 хөрөнгө оруулалтын ажлыг төсвийн төсөлд тусгасан байна.**

Улсын төсвийн хөрөнгө оруулалтад тусган хэрэгжүүлэхээр төлөвлөж зураг төсвийг орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийсэн боловч улсын төсөвт тусгагдаагүй шалтгаанаар 42.3 сая төгрөгөөр хийсэн зураг төсөв ашиглалтгүй болж, төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах эрсдэл үүссэн байна. Тухайлбал:

1. “Найрамдал хотхоны 1, 15 дугаар байрны дундах тоглоомын талбай, тохижилтын ажил”-ыг 2024 онд 12.0 сая төгрөгөөр Наран рашаан ХХК төсөв боловсруулж магадлалаар баталгаажуулсан байна. 2022 онд Ориентпльос ХХК 20.0 сая төгрөгөөр зогсоол, тоглоомын талбайн зураг төсвийг боловсруулан хүлээлгэж өгсөн ч тухайн зураг төсвийг төлөвлөлтийн уялдаа холбоогүй байдлаас шалтгаалан цаашид ашиглахгүй байх нөхцөл үүсэж байна.
2. “Халдвартын эмнэлэгийн их засварын ажил”-ын зураг төсвийг 2021 онд ММ Архитектур ХХК 14.8 сая төгрөгөөр гүйцэтгэж хүлээлгэн өгсөн боловч уг ажилд дээрх зураг төсвийг ашиглаагүй.
3. “Хуучин хүүхдийн эмнэлгийг оффиссын зориулалтаар засварлах ажил”-ын зураг төсвийг 2021 онд Эрхэс констракшн ХХК-иар 7.5 сая төгрөгөөр хийлгэсэн боловч уг барилгыг албан байрны чиглэлээр ашиглахаар болсон тул дээрх зураг төсвийг ашиглах боломжгүй болж байна.

Мөн аймгийн 2025 оны төсвийн төсөлд хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсвийн задаргааг хавсаргаж ирүүлээгүй нь Төсвийн тухай хуульд заасан төсөвлөлтийн шаардлага хангаагүй 555.3 сая төгрөгийн зардлыг төлөвлөсөн байна. Үүнд:

1. “Төрийн байгууллагад шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах ажил”-405.3 сая
2. “Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд 30 га талбайд мод тарих ажил”-150.0 сая

Энэ нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.2.3.3²¹-т заасан шаардлагыг хангаагүй байна.

Хотын насос станцын засварын ажил: 2020 онд Илчит сансар ХХК “Бохирын өргөх станцын өргөтгөл”-г 147.8 сая төгрөгөөр шинээр барьж ашиглалтад хүлээлгэн өгсөн боловч хүлээн авсан цагаасаа хойш зориулалтын дагуу ашиглаагүй, эвдэрсэн. Энэ нь Захиалагч, гүйцэтгэгч, хяналт хэрэгжүүлэгч байгууллагуудын уялдаа холбоогүй байдлаас шалтгаалсан бөгөөд эвдрэл гэмтлийг Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3²², 14.6²³-т заасан

²¹ 3.2.3.3.холбогдох баримт бичиг, нотлох баримтаар баталгаажсан, төлөвлөлт, зорилгод нийцсэн, хэрэгцээ шаардлагад тулгуурласан байх;

²² 14.3.Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаа нэг жил байна.

²³ 14.6.Энэ хуулийн 14.3-т заасан хугацаа дуусгавар болсноос хойш барилга байгууламжийн гадна, дотор засал, бүх төрлийн материал, үндсэн хийц, бүтээц, цэвэр, бохир ус, уур, хий, дулаан, цахилгаан, харилцаа холбооны тоног төхөөрөмж, тоноглолын хэвийн ашиглалтын хугацаа гурваас доошгүй жил байна.

хугацаанд шийдвэрлэж чадаагүйгээс 2025 оны төсөвт **50.0 сая** төгрөгийг засварын ажилд тусгаж, төсвийг үрэлгэн байдлаар зарцуулахаар төлөвлөсөн байна.

Төсвийн санхүүжилтийн үр ашгийг сайжруулах санал-3,546.6 сая

- “Өгөөж захын уулзвараас 2 дугаар сургуулийн уулзвар хүртэлх авто замын ажил”-1,000.0 сая, “Авто замын үерийн хамгаалалтын барилга байгууламж”-200.0 сая, “Усан спорт сургалтын төвийн засварын ажил”-400.0 сая, нийт **1,600.0 сая төгрөгийн 3 ажлын зураг төсөв батлагдаагүй тул дээрх ажлуудыг магадлалаар баталгаажсан төсөвт нь үндэслэн батлах, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор төлөвлөлтийг сайжруулах**
- “Халдвартын эмнэлгийн их засварын ажил”-550.0 сая, “Эрүүл мэндийн газрын хуучин барилгыг офиссын зориулалтаар засварлах ажил”-361.3 сая, “Хуучин хүүхдийн эмнэлгийг офиссын зориулалтаар засварлах ажил”-480.0 сая, нийт **1,391.3 сая** төгрөгийн 3 засварын ажилд “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.2.3.4²⁴-т заасны дагуу ашиглалтын байдал, цаашид төлөвлөсөн зориулалтаар ашиглах боломжтой эсэхэд **мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулах, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор төлөвлөлтийг сайжруулах**
- “Төрийн байгууллагад шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах ажил”-405.3 сая, “Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд 30 га талбайд мод тарих ажил”-150.0 сая нийт **555.3 сая** төгрөгийн 2 арга хэмжээний зардлын задаргааг аудитын хугацаанд гаргаж ирүүлээгүй тул төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг сайжруулж, хууль журамд нийцүүлэн боловсруулж батлуулах

Авто замын сан

УИХ, Сангийн яамнаас авто замын санг 1,006.0 сая төгрөгөөр хянаж баталсан бөгөөд аймгийн ТЕЗ-аас 168.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн нийт 1,174.2 сая төгрөгийг аймгийн 2025 оны төсвийн төсөлд тусгасан байна. Нэмэгдсэн эх үүсвэрийг авч үзвэл 32.2 сая төгрөгийн шилжих ажил, 116.0 сая төгрөгийг 2024 оны авто замын сангийн хэмнэлтээс, 20.0 сая төгрөгийг авто замын сангийн өөрийн орлогоос тус тус нэмэгдүүлэн төлөвлөжээ.

Авто замын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3²⁵, 24.4²⁶, 24.5²⁷ дахь заалтууд, Засгийн газрын 2019 оны 312 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам”-аар авто замын сангийн хөрөнгийг зарцуулахаар төлөвлөсөн байна.

Аймгийн 2025 оны төсвийн төсөлд 847.0 сая төгрөгийн 4 хөрөнгө оруулалтын ажил, 295.0 сая төгрөгийн 3, өмнөх оноос шилжсэн 32.1 сая төгрөгийн 1 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тус тус төлөвлөжээ.

Үүнээс хуульд заасан шалгуурыг хангаагүй буюу Авто замын сангийн чиг үүрэгт хамааралгүй авто зам, зогсоол барих 668.6 сая төгрөгийн 3 ажлыг төлөвлөсөн нь Авто замын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.8²⁸-т заасныг зөрчсөн байна.

*Авто замын тухай хууль, авто замын сангийн журамд
нийцээгүй ажлын жагсаалт*

²⁴ 3.2.3.4.тухайн барилга байгууламжийн ашиглалт, норм, хугацаа, элэгдлийн байдал, мэргэжлийн байгууллагын гаргасан дүгнэлт, засварын хөрөнгийн төсөв, холбогдох баримт бичигт үндэслэсэн байх.

²⁵ 24.3.Улсын авто замын сангийн хөрөнгөөр олон улс, улсын чанартай авто замын, нийслэл, орон нутгийн замын сангийн хөрөнгөөр нийслэл, орон нутгийн чанартай авто замын арчлалт, засварын ажлыг тус тус санхүүжүүлнэ.

²⁶ 24.4.Авто замын сангийн хөрөнгөөр авто замын арчлалт, урсгал засвар, гэнэтийн хүчин зүйлээс хамаарсан засварын ажлыг тэргүүн ээлжинд санхүүжүүлнэ.

²⁷ 24.5.Авто замын сангаас авто замын засвар, арчлалтын ажлыг хариуцсан байгууллагын үйлдвэрлэлийн баазыг бэхжүүлэх, судалгаа шинжилгээний ажил хийх, техник технологийг шинэчлэх, хөндлөнгийн хяналт тавих, хөдөлгөөнт эргүүл ажиллуулах, мэргэжилтэн бэлтгэх, мэргэшүүлэх, авто замын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг санхүүжүүлнэ.

²⁸ 24.8.Авто замын сангийн хөрөнгийг энэ хуулийн 24.3, 24.4, 24.5-д зааснаас бусад зориулалтаар зарцуулахыг хориглоно.

Хүснэгт №10

(сая.төг)

№	Хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ	Төсөвт өртөг
1	Найрамдал хотхоны 6 дугаар байрыг авто замтай холбох	44.6
2	Найрамдал хотхоны 6, 10, 11, 1-р байрны өмнөх авто зам, зогсоолыг сайжруулах	365.1
3	Найрамдал хотхоны 1, 15-р байрны дундах авто зогсоол байрыг замтай холбох ажил	258.8
Дүн		668.6

(Эх сурвалж: Аймгийн 2025 оны төсвийн төсөл)

Авто замын сангийн 2020 оны хөрөнгө оруулалтаар Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГ-т хог хаягдал цэвэрлэх бичил авто машиныг 114.4 сая төгрөгөөр худалдан авч хүлээлгэн өгсөн боловч ашиглалтын шаардлага хангахгүй байгаагаас өнөөдрийг хүртэл ашиглаагүй нь хөрөнгө оруулалтын ажлын үр нөлөөг бууруулж байна.

Төсвийн санхүүжилтийн үр ашгийг сайжруулах санал-668.6 сая

- Хууль, журмаар хориглосон 668.6 сая төгрөгийн дээрх 3 ажлыг Авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажлын жагсаалтаас хасах, шаардлагатай тохиолдолд Орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх

Төсвийн зарлагыг бууруулах санал-178.8 сая

- 2020 оны Авто замын хөрөнгөөр худалдан авсан 114.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй гудамж талбай цэвэрлэх бичил автомашин нь одоог хүртэл ашиглалтгүй байна. Мөн ашиглагч байгууллагаас авто замын цэвэрлэгээ, арчилгааны автомашиныг худалдаж авах санал, холбогдох зардлын тооцоо судалгааг ирүүлээгүй, өмнө худалдан авсан төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаагүй, төсвийн хөрөнгийн үр ашгийг тооцохгүй хөрөнгийг давхардуулан авахаар төлөвлөсөн тул “Авто замын цэвэрлэгээ арчилгааны автомашин худалдаж авах” 178.4 сая төгрөгийн ажлыг хасах - Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.1.3, 4.1.7, 4.1.9 дэх заалтыг зөрчсөн.
- Авто замын сангийн хэрэгжүүлэх арга хэмжээний зардалд 0.4 сая төгрөгийн Татварын байгууллагын чиг үүрэгт хамаарах урсгал зардлыг хасах-Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.1.3, 4.1.7, 4.1.9 дэх заалтыг зөрчсөн.

Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээ

Орон нутгийн 2025 оны төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэлийн 2 дугаар зүйлийн 2.3-т “Сангийн яам хянаж, Засгийн газраас өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал баталсан түвшнээс бууруулахгүйгээр орон нутгийн төсөвт тусгаж батлуулах” чиглэлийг аймгийн Засаг даргад хүргүүлсэн байна.

Сангийн яамнаас 2025 оны орон нутгийн төсвийн суурь зарлагад тус арга хэмжээний зардлыг 371.3 сая төгрөгөөр хянасан бөгөөд уг дүнгээр аймгийн төсвийн төсөлд тусгасан ба БХНСАХЗ-аас аймагт 265.4 сая, Сүмбэр суманд 77.4 сая, Шивээговь суманд 25.8 сая, Баянтал суманд 2.7 сая төгрөгийг тус тус хуваарилсан байна.

Байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээний зардалд 2025 онд шинээр хэрэгжүүлэх 4 ажилд 60.0 сая, 9 арга хэмжээнд 205.4 сая нийт 265.4 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна. Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1²⁹-т заасны дагуу ашигласан нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих зарцуулах зохицуулалттай байна.

²⁹ 3.1.Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасан хувь, хэмжээний доод хязгаартай тэнцэх төлбөрийн орлогын хэсгийг тухайн ашигласан нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээнд зарцуулна.

Говьсүмбэр аймгийн хэмжээнд Байгалийн нөөц ашигласны тухай хуульд заасан орлогын эх үүсвэр бүрээр орлого төвлөрдөггүй бөгөөд газрын төлбөр, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр, ан амьтны нөөц ашигласны төлбөр, ус, рашааны нөөц ашигласны төлбөрөөс эх үүсвэр бүрддэг тул мод тарих, усалгааны худаг гаргах зэрэгт 151.6 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна.

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 83.3 хувьтай байна.

2024 оны орон нутгийн төсвийн төслийн аудитаар дараах зөвлөмжийг өгсөн байна.
Үүнд:

1. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөг хуулийн хугацаанд ИТХ-аар хэлэлцүүлж, батлуулах-хэрэгжилт-70 хувь
2. Төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэхдээ бодит, тооцоо судалгаанд тулгуурлах, байгууллагуудын ирүүлсэн саналд дүн шинжилгээ хийх-90 хувь
3. Жил бүр тасарч буй татварын орлогын шалтгаан нөхцөлийг тодруулж дүн шинжилгээ хийх, төрийн байгууллагуудын мэдээллийн уялдаа холбоог сайжруулж, татварын ногдол, хуримтлагдсан өр төлбөрийг барагдуулах ажил зохион байгуулах-90 хувь

Гүйцэтгэлийн аудитаар орон нутгийн 2025 оны төсвийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх 740.5 сая төгрөгийн 4, зардлыг бууруулах 279.2 сая төгрөгийн 7, 6,095.2 сая төгрөгийн 13 хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үр ашгийг сайжруулах 6 санал, 3 зөвлөмжийг гаргаж аймгийн ИТХ, Засаг даргад хүргүүлээ.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

- Төсвийн тухай хуулиар баталсан орлогын доод хэмжээний хязгаарыг зөрчиж, 3 нэр төрлийн 494.0 сая төгрөгийн татварын орлогыг төсвийн төсөлд бууруулсан байна.
- 2024 оны хэмнэгдсэн зардлын дүнг тооцоо судалгаанд үндэслэн төсвийн төсөлд тусгаагүй байна.
- , төсвийн зарлагыг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөөгүй байна.
- Аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөг хуулийн хугацаанд боловсруулж, АИТХ-аар батлуулаагүй байна.
- Төсвийн урсгал зардлын төлөвлөлтийг Засгийн газрын 2019 оны 445 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн төсвийн суурь зарлагыг тооцох аргачлал”-ын дагуу тооцож төлөвлөөгүй байна.
- Төсвийн төсөлд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-г заасан аймгийн чиг үүрэгт хамааралгүй урсгал зардлыг төлөвлөсөн, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд баримтлах зарчим, Төсвийн тухай хуульд заасан шалгуурт нийцүүлэн арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэй байх, төсвийн урсгал зардлыг хэмнэх, хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг эдийн засгийн үр ашигтай, нийгэмд ач холбогдолтой байхаар хүрэх үр дүнг тооцож төлөвлөөгүй, **279.2 сая төгрөгийн урсгал зардал, хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн шаардлагад нийцээгүй 6,095.2 сая төгрөгийн нийт 13 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.**
- Төлөвлөлтийн уялдаа холбоо алдагдсанаас 2020-2024 оны хооронд хэрэгжүүлэхээр төлөвлөж 42.3 сая төгрөгөөр 3 ажлын зураг төсөв хийсэн боловч улсын төсөвт батлагдаагүй шалтгаанаар ашиглалтгүй болж төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдаж байна.
- Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 83.3 хувьтай байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын нотлох баримт, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАД:

1. Аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөг Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу 18 дугаар зүйлийн 18.5, 18.6-т заасан хугацаанд боловсруулж аймгийн ИТХ-аар батлуулах
2. ОНХО, ОНХС, Авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнд төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг тусгахгүй байх, зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай төсөл, арга хэмжээний зураг төсвийг боловсруулж батлуулах, зардлын задаргаа, ажлын даалгавар, холбогдох тооцоо судалгааг иж бүрэн гаргах, хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэх
3. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн зураг төсвийн ажлыг хүчинтэй байх хугацаанд нь буюу 2 жилийн дотор ашиглах, улсын төсөвт тусгуулж хэрэгжүүлэх ажлын зураг төсвийг нэн тэргүүний хэрэгцээ шаардлага, ач холбогдол зэргийг харгалзсаны үндсэн дээр боловсруулах, өмнө хийгдсэн хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулахгүй, төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаагүй, төсвийн хөрөнгийн үр ашгийг тооцоогүй хөрөнгийг давхардуулан авахаар төлөвлөхгүй байх

Зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 10-ны дотор, Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-т “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор Төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасан хугацаанд тус тус ирүүлэх

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛД

1. Орлогыг нэмэгдүүлэх санал-740.5 сая
2. Төсвийн зарлагыг бууруулах – 279.3 сая
 - 2.1 Урсгал зардлыг бууруулах-100.5 сая
 - 2.2 Автозамын сангийн зардал – 178,8 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээ
3. Төсвийн үр ашгийг дээшлүүлэх – 6,095.2
 - 2.1 Орон нутгийн хөрөнгө оруулалт –3,546,6 сая төгрөгийн 8 төсөл, арга хэмжээ
 - 2.2 Орон нутгийн хөгжлийн сан-1,800.0 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээ
 - 2.3 Автозамын сан- 668.6 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээ
 - 2.4 Гамшгаас хамгаалах арга хэмжээний зардал-80.0 сая төгрөгийн 1 арга хэмжээ

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг,
Найрамдал хотхон, Утас/Факс: (976) 7054 3005,
И-мэйл: zdtg.gsa@gmail.com, Вэбсайт: www.govisumber.gov.mn

2024.12.02 № А/1189

танай _____-ны № _____-т

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

“Аймгийн 2025 оны төсвийн төсөл”-д өгсөн аудитын
тайлан дахь холбогдох саналуудыг харгалзан үзэж
төсөвтөө тусган ажиллах болно.



Т.БАТ-ЭРДЭНЭ

Аймаг агуулах
Б. Доржпалмаа
Найрамдал хотхон
орлогч

2024.12.02

4200400653

Төсвийн байгууллагуудын 2024 оны зардлын хэмнэлтийн тооцоо

(Мянган төгрөг)

№	Байгууллагын нэр	Жилийн төсөв	Цалин хөлс	НДШ	Тогтмол зардал	Эд хогшил худалдан авах	БГБНТАУТХ /Мэдээлэл сурталчилгааны зардал/	Нийт дүн	Тайлбар
1	АИТХ төсөв	1,067,300.0	39,105.1	6,878.6				45,983.7	2 орон тоо дутуу ажилласан
2	АЗДТГ төсөв	5,716,700.0	138,848.1	30,679.3	7,000.0	57,232.9	23,790.0	257,550.2	10 орон тоо дутуу ажилласан
3	ОНӨГазар	259,000.0	25,501.9	4,808.5				30,310.4	4 орон тоо дутуу ажилласан
4	Худалдан авах ажиллагааны газар	255,100.0	21,499.5	4,814.4				26,313.8	3 орон тоо дутуу ажилласан
5	СХДАА		16,185.5	2,654.5				18,840.0	1 орон тоо дутуу ажилласан
6	БОАЖГ	652,420.0	10,596.1	3,618.3	4,259.6			18,474.0	1 орон тоо дутуу ажилласан
7	СДОАнги	348,000.0	18,568.5	3,408.9				21,977.4	8 орон тоо дутуу ажилласан
8	ЦСҮТ	261,800.0	1,775.9	4,269.0	2,010.9			8,055.7	Цалингийн зардлын хэмнэлт
9	Боловсролын тогтмол	800,000.0			404,706.9			404,706.9	Тогтмол зардлын хэмнэлт
10	Эрүүл мэндийн тогтмол				132,086.2			132,086.2	Тогтмол зардлын хэмнэлт
11	Соёлын тогтмол				17,808.3			17,808.3	Тогтмол зардлын хэмнэлт
12	Сүмбэр ЗДТГ	2,224,437.0	63,811.3	21,901.3	18,384.6			104,097.2	3 орон тоо дутуу ажилласан
13	Сүмбэр ИТХ	303,430.0	7,490.8	1,364.7				8,855.5	1 орон тоо дутуу ажилласан
14	Шивээговь ЗДТГ	1,326,743.1	72,371.2	12,172.5	14,428.8			98,972.5	5 орон тоо дутуу ажилласан
15	Шивээговь ИТХ	237,455.4	7,923.4	1,658.1				9,581.5	Цалингийн зардлын хэмнэлт
16	Баянтал ЗДТГ	1,092,528.5	37,307.4	5,636.5	7,665.6			50,609.4	4 орон тоо дутуу ажилласан
17	Баянтал ИТХ	186,391.0	14,289.5	2,289.7				16,579.2	Цалингийн зардлын хэмнэлт
	Нийт	14,731,305.0	475,274.0	106,153.9	608,350.9	57,232.9	23,790.0	1,270,801.7	-